



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2024 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/501

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн "Дүрэм"-ийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.9.3, "Гишүүнчлэлийн журам"-ын 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гүйцэтгэх захирлын 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/396 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрхийг нь хязгаарласан "Өндөрхаан инвест ҮЦК" ХХК нь гаргасан зөрчлөө арилгаж, үйлчилгээний хөлсөө төлсөн тул арилжаанд оролцох эрхийг 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. "Өндөрхаан инвест ҮЦК" ХХК-ийн үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үгийг сэргээхийг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т үүрэг болгосугай.
3. Монгол Улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, заавар болон "Гишүүнчлэлийн гэрээ"-гээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлж ажиллахыг "Өндөрхаан инвест ҮЦК" ХХК (Н.Оюунтунгалаг)-д даалгасугай.
4. Гүйцэтгэх захирлын 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/396 дугаар тушаалыг 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.
5. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын алба (Ч.Эрдэнэболор)-нд тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



*M. UBA*

Ж.ЦОГТБАЯР

1524031090